



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 25 өдөр

Дугаар А/44

Хэрлэн сум

Шагнаж, урамшуулахад хөрөнгө
зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалт, Аймгийн Засаг даргын 2015 оны А/562 журам батлах тухай захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төрийн үйлчилгээг түргэн, шуурхай хүргэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан байгууллага, албан хаагч, хувийн хэвшлийг шагнаж урамшуулсугай.

2. Шилдгээр шалгарсан хамт олон, байгууллагын дарга, албан хаагчдыг шагнаж урамшуулахад 3,095,000 (гурван сая ерөн таван мянга) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

3. Шилдэг төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын нэрс, зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

4. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын нөөц сангийн шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэгийн зардлаас олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231010190

Аймгийн Засаг даргын 2022 он
 01 дүгээр сарын 25 өдрийн
 дугаар захирамжийн хавсралт



Шилдэг төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын нэрс,
 зардлын тооцоо

№	Байгууллагын нэр	Урамшууллын мөнгөн дүн	Батламжийн үнэ	Бүгд үнэ
Шилдэг төрийн байгууллага				
1	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар	500,000	60,000	560,000
2	Татварын хэлтэс	500,000	60,000	560,000
3	УЦУОШТөв	100,000	50,000	150,000
4	Онцгой байдлын газар	100,000	50,000	150,000
5	Эрүүл мэндийн газар	100,000	50,000	150,000
6	Мал эмнэлгийн газар	100,000	50,000	150,000
Шилдэг хувийн хэвшлийн байгууллага				
7	Ханбүргэд Хэрлэн ХХК	500,000	60,000	560,000
8	Дацан трейд ХХК	500,000	60,000	560,000
Шилдэг ажилтан				
9	Хэсгийн төлөөлөгч 1	100,000	27,500	100,000
10	Хэсгийн төлөөлөгч 2	100,000	27,500	100,000
	Дүн	2,600,000	495,000	3.095.000